



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх
өндөржүүлсэн бэлэн байдлын горимд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241, А/1242 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 14, 15 дугаар хуралдааны тэмдэглэл, төвийн даргын 2019 оны А/10 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.5, 10.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах тусгай горимд шилжүүлсүгэй.

2.Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах төлөвлөгөөг 1 дүгээр, ажлын тусгай горимыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан төвийн түр хоноглох байранд байрлаж буй иргэдийн гарах хөдөлгөөнийг хязгаарласугай.

ДАРГА



Г.ЦЭРЭНДУЛАМ

318060281

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2020 оны 11 сарын 11 ны өдрийн
А/Бодуугаартай тушаалын 1 дүгээр хавсралт



БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 оны 11 дүгээр сарын 11

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах нэгж, ажилтны нэр	Хугацаа
1	2	3	4
1	"Маскаа зүүцгээе- гараа угаая" аяны хэрэгжилтийг эрчимжүүлэх	Эмч, нийгмийн ажилтнууд	
2	Иргэдийн гарах хөдөлгөөнийг хязгаарлах	Нийгмийн ажилтан, жижүүр, хариуцлагатай жижүүр	Өдөр бүр
3	Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх	Нийт ажилтнууд	Өдөр бүр
4	Өрөө тасалгааны болон гадна орчны цэвэрлэгээ, агаар сэлгэлт, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийх, хяналт тавих	Эмч, үйлчлэгч, жижүүр, хариуцлагатай жижүүр	Өдөр бүр
5	Шаардлагатай эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хэрэгслийн хангалт хийх	Эмч, Нягтлан бодогч, нярав	-
6	Гэрт иргэд хүлээн авах бэлэн байдлыг хангах, түлшний мод, шахмал түлш татан нөөцлөх	Нягтлан бодогч, нярав	-
7	Иргэдийн хүнсний бараа материал болон зөөлөн эдлэл хувцасны худалдан авалт, хадгалалтыг нэмэгдүүлэх	Нягтлан бодогч, нярав	-
8	Ажилтан албан хаагчдыг нэг удаагийн хамгаалах хэрэгслээр хангах /малгай, бээлий, амны хаалт, комбинзон, ...г м/	Эмч, Нягтлан бодогч, нярав	-
9	Хүндэтгэх шалтгаантай ажилтан албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлөөр хангах	Ахлах арга зүйч	
10	Иргэд болон ажилтнуудад дархлаа дэмжих аарц, чацаргана өгөх	Нягтлан бодогч, нярав, тогооч нар	Өдөрт нэг удаа
11	Дасгал, хөдөлгөөн тогтмол хийлгэх	Эмч, хариуцлагатай жижүүр, жижүүрүүд	Өдөрт 2 удаа
12	Иргэдэд өдөр тутмын мэдээллийг өрөө өрөөнд нь хийх	Хариуцлагатай жижүүр, эмч	Тухай бүр
13	Мэдээ тайланг тогтоосон хугацаанд холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэх	Бичиг хэргийн ажилтан	Өдөрт 2 удаа

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АРГА ЗҮЙЧ *Н.НЭРГҮЙ* Н.НЭРГҮЙ

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2020 оны 11 сарын 11-ны өдрийн
1/15 дугаартай тушаалын 2 дугаар хавсралт



БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ТУСГАЙ ГОРИМ

1. Нийт ажилтан албан хаагчид Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах
2. Халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, иргэдэд тавих хяналтыг өндөржүүлэх
Үүнд:
 - 2.1. Иргэдийн гарах орох хөдөлгөөнийг зогсоох, шаардлагатай тохиолдолд удирдлагад мэдээлэх
 - 2.2. Өглөө, оройд / мөн шаардлагатай үед / иргэдийн халууныг тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй тохиолдлыг тусгаарлах, мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
 - 2.3. Хоёр цаг тутамд иргэдийн гарыг угаалгаж, амны хаалтыг угааж индүүдүүлэх
 - 2.4. Өрөө тасалгаа, гадна орчны цэвэрлэгээ, ариутгалыг тухай бүр чанартай хийж, тогтмол хяналт тавин ажиллах
 - 2.5. Иргэдийг 2 ээлжээр хооллох, гэрт шинээр байрласан иргэдэд хоолыг нь зөөж өгөх
3. Гаднаас өөрийн хүсэлтээр болон цагдаагийн албан хаагчийн шаардлагын дагуу ирсэн иргэдийг тусгаарлах дэгийг сахиулан гэрт байрлуулах
 - 3.1. Иргэний халууныг хэмжиж, асуумж авч, эмчид үзүүлж шийдвэрлэх
4. Дархлаа дэмжих халуун шингэн зүйл уулгах, аарц, чацаргана нэмэлтээр олгох
5. Өдрийн хоолны дараа 2 цаг унтаж амрах дэглэм тогтоох
6. Ажилтнууд иргэдэд болон бие биендээ хүлээцтэй, хүндэтгэлтэй хандаж, стресс бухимдалгүй, хариуцлагатай ажиллахыг анхааруулъя.